

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2023  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.06.13

Аймгийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, байгууллагын гүйцэтгэсэн ажлын 7 хоногийн мэдээг 52 удаа аймгийн ЗДТГазарт, 1,2,4,5 дугаар сарын болон 1 дүгээр улирлын тайланг аймгийн БОАЖЯам, ЗДТГазарт цахим болон бичмэлээр хүргүүлэн ажиллаа.

Аймгийн ИТХ-аар аймгийн "Аялал жуулчлалын дэд" хөтөлбөр, БОАЖСайдын 2023 оны А/05 дугаар тушаалын дагуу "аймгийн нутаг дэвсгэрээс ахуйн зориулалтаар агнах, барих амьтны дээд хязгаар тогтоох" тухай 135 дугаар тогтоол, "ойгоос бэлдэх модны дээд хязгаарыг тогтоох" тухай 123 дугаар тогтоолыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 99 иргэн, ААНэгжийн төслийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж БОАЖЯамны мэдээллийн санд оруулав.

Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу 2022оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг сум тус бүрээр/eic.mn /finance/ мэдээллийн санд, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолын дагуу байгууллагын төрийн захиргааны албан хаагч нарын ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталж, хүний нөөцийн мэдээллийн санд, Амьтан, ой, усны нөөц ашиглалт, хомсдол, доройтол, нөхөн сэргээлт, хамгаалал, Энгийн хатуу хог хаягдал, дахин ашиглалт, боловсруулалт болон аюултай хог хаягдлын 2022 оны мэдээг БОХА маягтын дагуу сум тус бүр БОАЖЯамны статистик мэдээллийн санд оруулж ажиллав.

БОАЖСайд тус аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Ёс зүйн зөвлөлийн тайлан, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлан, Хүний нөөцийн бүрэлдэхүүн, шилжилт хөдөлгөөний тайлан, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хагас жилийн байдлаар гаргаж аймгийн ЗДТГазарт хүргүүлэв.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:**

Аймгийн Цагдаагийн газар, Өлгий сумын ЗДТГазартай хамтарч нэгдсэн хяналт шалгалтыг зохин байгуулж, хууль бусаар мод бэлтгэсэн, ан амьтан агнасан, байгалийн ургамал түүж бэлтгэсэн, хог хаягдал ил задгай хаясан зөрчилд нийт 2 аж ахуйн нэгж, 6 иргэнд 1,710,000 төгрөгийн торгууль, 120.000 төгрөгийн нөхөн төлбөр тавьж 100% барагдуулж, хяналт шалгалтын явцад хураагдсан 3 ширхэг загасны тор, 12 ширхэг монгол хадран загас, 397 кг барагшуныг Өлгий, Дэлүүн сумдын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн шийдвэр гаргуулан ажиллав. Хууль бусаар 1 тооны зэгсний гахай агнасан, Баяннуур сумын 03 дугаар багийн нутаг дэвсгэрт орших ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүй 162 ширхэг эсгий гэрийн мод бэлтгэсэн, хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал болох хайрга олборлож тээвэрлэсэн 2 зөрчлийг илрүүлж, зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж харьяаллын дагуу шалган шийдвэрлүүлэхээр Цагдаагийн газарт шилжүүлэв.



Ховд голын эрэг дагуу хяналт шалгалт хийж, хууль бусаар голын эргээс хайрга олборлож тээвэрлэсэн 2 зөрчлийг илрүүлэн, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллалаа.



БОАЖЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан 01/05 тоот “Ан агнах, барих, худалдах, худалдан авах, тээвэрлэх, байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх



тухай удирдамжийн дагуу аймгийн БОАЖГ-ын Байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагч, байгаль хамгаалагч нар 2023 оны 05 дугаар сарын 17, 19-ны өдрүүдэд Толбо сумын нутаг дэвсгэрт орших Толбо нуур, Хар нуураас загасны үржлийн үед загас агнаж байгаа байдалд хяналт шалгалт хийх явцад Өлгий сумын иргэн Н болон Т нь хууль бусаар загас агнасан зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан хариуцлага хүлээлгэж ажиллалаа.



Аймгийн Засаг даргын 2022 оны 11-р сарын 09-ний өдрийн А/871 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А-479 тоот тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ыг баримтлан орчны бохирдол болон утааг багасгахын тулд аймгийн төвийн “А” бүсэд үйл ажиллагаа явуулдаг нам даралтын зуухтай аж ахуйн нэгж байгууллагуудын судалгаа авч, нэгдсэн халаалтад холбох, шүүлтүүр, үнс баригч тавиулах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.



БОАЖЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан 01/05 тоот “Ан агнах, барих, худалдах, худалдан авах, тээвэрлэх, байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай, 01/04 тоот “Ой, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, худалдаалах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай”, аймгийн БОАЖГ-ын даргын баталсан 02 тоот “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжуудын дагуу Алтанцөгц, Баяннуур сумдын нутаг дэвсгэрт аймгийн БОАЖГ-ын дарга ахалсан байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй 2023 оны 04 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд хяналт шалгалт хийж ажиллав. Хяналт шалгалтаар тухайн газар нутагт оршин суудаг иргэдэд 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс загасны үржлийн үе эхэлж байгаатай холбогдуулан хууль бусаар загас, ан амьтан агнахгүй байх, 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа эхэлж байгаа талаар заавар зөвлөмж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгууллаа.



Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулдаг Н. ХХК-ийн захирал Д-гийн гомдлын дагуу Өлгий сумын 4 дүгээр багт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн Б-гийн биологийн идэвхт бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг түр зогсоож, зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллав.



Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр баталсан "Уурын болон усан халаалтын зуухны яндангийн утаанд агуулагдах агаар бохирдуулагч бодис стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд шинжилгээтэй хяналт шалгалт хийх тухай" удирдамжын дагуу Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгуулагуудад хяналт шалгалт хийж ажиллаж байна.





БОАЖСайдын 2023 оны 02 дугаар албан даалгавар болон БОАЖЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан 01/14 тоот “Байгаль орчны хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Өлгий, Буянт, Улаанхус сумын Согоог, Хөх хөтөл багт үйл ажиллагаа явуулж буй ШТСтанц, нам даралтын зуух ашигладаг ААНэгж байгууллагуудад БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нар орчны бохирдлыг бууруулах, эрүүл, аюулгүй цэвэр орчныг бүрдүүлэх зорилгоор нам даралтын зууханд шүлтүүр тавиулах, нүхэн жорлонг буулгаж MNS5924:2019 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар зөвлөгөө, даалгавар өгч ажиллав. 2023 оны эхний хагас жилийн байдлаар “Тес петролиум” 3 ширхэг, МТ 3 ширхэг, “Рысжан” 3 ширхэг, “НИК” 2 ширхэг, “ХӨРС” 2ширхэг, Цэнгэл суманд 1 ширхэг нийт 15 еко жорлон барьж байгуулав.



“Өлгий-Ойл” ХХК-ийн ШТС-ын үйл ажиллагаанд 2023 оны 05-р сарын 24-ний өдөр 01.1.4 кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг



шалгах хяналтын хуудас"-аар төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтуудыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.



Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа “Мега” авто засвар, угаалгын газар, “Даян” авто засварын газруудын үйл ажиллагаанд 01.1.4 кодтой хяналтын хуудсаар төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, эрсдэлийг үнэлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажиллав.



Өлгий суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Балбалтас” Чулуу боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд 2023 оны 05-р сарын 26-ний өдөр 01.1.4 кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас"-аар төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэн ажиллаж байна.





2023 оны 05-р сарын 25,26-ны өдрүүдэд БОАЖГазрын дарга, Ойн асуудал хариуцсан мэргэжилтэн нар Цэнгэл, Сагсай суманд ажиллаж тус сумуудад БОАЖСайдын 2023 оны 02,05 дугаар албан даалгаврын хэрэгжилт, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны ургалтын байдалтай танилцаж, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор нүхэн жорлонг буулгаж, стандартын шаардлага хангасан эко жорлонтой болох, зүй бусаар болон байгалийн гамшгийн улмаас хорогдсон мал амьтны сэг зэмийг мал эмнэлгийн хяналтын доор халдваргүйтгэх болон устгах, ил задгай хаясан хог хаягдлыг иргэн аж ахуй нэгж байгууллагуудыг татан оролцуулж тогтмол цэвэрлэх ажлыг зохион байгуулах талаар тус сумын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нарт хугацаатай үүрэг, даалгавар өгч ажиллав.



#### **СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:**

Орон нутгийн хэвлэл мэдээлэлээр амьтаны тухай хууль, байгалийн ургамлын тухай хууль, усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны тухай хууль болон Монгол улсын Улаан номонд орсон ховор амьтан,түний экологи, эдийн засгийн үнэлгээний талаар сурталчлах ажлыг зохион байгууллаа.



Дэлхийн амьтан, ургамлыг хамгаалах өдрийг угтаж “Ховд голын эх ба эмэгтэйчүүд” сэдэвт зөвлөгөөнийг МАНУТХГХЗахиргаа, МЭХ-ны Баян-Өлгий аймаг дахь салбар ба ХТАлбатай хамтарч зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн төлөөлөгч болох 300 гаруй эмэгтэйчүүд хамрагдлаа. Уг арга хэмжээнд Монголын тандан судлаачдын холбооны захирал, Байгаль орчны тандан судлаач Байгаль ухааны доктор Б.Эрдэнэ оролцож, “Хог хаягдал-орчны бохирдол” сэдвийн хүрээнд мэдээлэл өглөө.



Байгаль орчин аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ тус аймгийн БОАЖГазар, МАНУТХГНХЗахиргаа, Хөх сэрхийн нурууны УТХГНХЗахиргаа, УЦУОШТөв болон СДОАнгийн албан хаагч нартай уулзаж, тулгамдаж буй асуудлыг сонсож, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, нүхэн жорлонгоос салах зэрэг үүрэг чиглэл өглөө. БОАЖСайд Б.Бат-Эрдэнэ байгаль орчны салбарт олон жил ажиллаж, байгаль орчноо хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулсан албан хаагчдад БОАЖЯамны жуух бичиг болон тэргүүний ажилтанаар шагнаж урамшуулав.



Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” танхим болон цахим сургалтад 29 албан хаагчдыг хамрагдаж, үнэмлэхээ гардан авсан.



Аймгийн ХДТеатрт Ерөнхий боловсролын сургуулийн 09-12 дугаар ангийн сурагчдад зориулсан “Хувь хүний хөгжил”-ийн сургалтыг “Ногоон Ирээдүй” төслийг хэрэгжүүлэгчид



болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Уг сургалтаар “Ногоон Ирээдүй” төслийн сургагч багш нар Мэргэжилдээ хэрхэн эзэн болох вэ? Ногоон дэлхий бидний ирээдүй, Хайрын 5 хэл, Нүүдэл, Сэтгэлгээний өөрчлөлт сэдвээр мэдээлэл өглөө. Сургалтад 300 гаруй ахлах ангийн сурагчид оролцлоо.



2023 оны 04-р сарын 12-ны өдөр 13 сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт “мэдлэг дээшлүүлэх, мэдээллээр хангах сургалт”-ыг зохион байгуулж, сургалтад ороолцсон БОХУБайцаагч нарт улсын байцаагчийн тамга болон “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл хэрэгжиж буй 6 сумын БОХУБайцаагч нарт дүрэмт хувцас гардуулан, 2023 онд хамтран ажиллах гэрээ байгуулав.



БОАЖЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II, III шатны санхүүжилтээр олгосон ухаалаг дэлгэц

ашиглан 13 сумын байгаль хамгаалагчдад цахим хурал зохион байгууллаа.



Ерөнхий боловсролын сургуулиудын эко клубуудын багш, сурагчдын төлөөлөлүүдэд байгаль орчныг хамгаалах дадал хэвшлийг бий болгох, эх дэлхийгээ хайрлан хамгаалахад сургах зорилгоор Боловсрол шинжлэх ухааны газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтарч “Ногоон хөгжил”, “Мэргэжил сонголтын ач холбогдол”, “Эко сургууль болох 7 алхам”, “Хөрсний бохирдол” сэдэвүүдээр сургалт зохион байгуулав. Уг сургалтад оролцсон 3 багш, 21 Эко клубийн сурагчидтай санал солилцож, 2023 онд хийх ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаа.



Аймгийн ГХУССЗөвлөлийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэг дүгээр зорилтын 1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн аймгийн гэмт хэргийн криминологийн судалгааны дагуу тогтоогдож буй гэмт хэрэг, зөрчлийн шалтган нөхцөлийг арилгах, иргэд болон төрийн албан хаагч нарын хуулийн мэдлэгийг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран Улаанхус, Цэнгэл суманд ажиллаж хууль бус ан агнуур, ой модны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулав.





Олон улсын музейн өдөр/05-р сарын 18/ийг тохиолдуулан эко клубийн 50 гаруй сурагчдад байгаль хамгаалах чиглэлээр “Хуурай газрын эко системийг хамгаалах” хэлэлцүүлэг, уулзалтыг аймгийн Музей, Насан туршийн боловсролын төвтэй хамтарч зохион байгууллаа.



БОАЖЯам, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн газартай хамтран хэрэгжүүлж буй “ВИОФИН-II” төсөлтэй хамтран ЗДТГазын ХБТХОХэлтэс, БОАЖГазар, аймгийн Татварын хэлтэс, ГХБХБГазрын холбогдох мэргэжилтэн, сумдын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нарт Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-хэрэгжилт, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, зарцуулалтын мэдээллийн сангийн талаар сургалт зохион байгууллаа. Сургалтаар Төслийн сургагч багш нар [www.eic.mn/finance](http://www.eic.mn/finance) системтэй хэрхэн ажиллах, байгалийн нөөц ашиглалтын төлөвлөлт, орлого, давсан орлогын зарцуулалтын мэдээллийг хэрхэн системд оруулах, хянах, тайлагнах талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгч ажиллав.



БОАЖЯам зохион байгуулсан Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын тушаалаар эрх олгогдсон Байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчдад орчны бохирдлыг бууруулах, хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон бодлого, шийдвэр хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа болон Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилготой 2 өдрийн сургалт,

“Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах талаар төрөөс баримталж буй бодлого, хууль, эрх зүйн орчин болон зэрлэг амьтан аврах, асран хамгаалах арга аргачлал, зэрлэг амьтанд үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээ, олон улсад хэрэгжүүлж буй сайн туршлага” талаар хэлэлцэх уулзалт, семинарт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба болон Дэлхийн байгаль хамгаалах сан(WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран зохион байгуулсан “Хууль бусаар ан агнах, ой, байгалийн ургамал бэлтгэх, худалдаалах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт танхимын сургалт, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох, үндэсний чадавхыг бэхжүүлэх (NAP)” төслийн газраас зохион байгуулсан “Үндэсний дасан зохицлын төлөвлөгөөний орон нутгийн хэлэлцүүлэг”, “НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах орон нутгийн дэд ажлын хэсгүүдтэй хийх цахим хуралд холбогдох албан хаагч нарыг оролцуулав.

### АН АМЬТНЫ ТАЛААР:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон агнуурын бүс нутаг хариуцагч менежментийн компаниудын санхүүжилтээр Буянт сумын “Эзэрлэг”, “Тошинт-Харгайт”, Дэлүүн сумын “Ахуунт”, “Улаан говь”, Бугат сумын “Төмөрт”, Улаанхус сумын “Агуйт-Хатуу”, “Мянган уул”, “Хүрэн уул”, Толбо сумын “Зурхайчийн нуруу”, “Борт”, Алтай сумын “Цалгарын цагаан булаг”, Алтанцөгц сумын “Мундуйн дэвсэг”, “Халуун Бардам”, Сагсай сумын “Бөхөн”, Цэнгэл сумын “Баян-Цэнгэл”, “Борбургас”, “Мөст булаг”, Ногооннуур сумын “Бахлаг”, “Модон овоо”. “Хавцал”. “Харлаг”, “Бураат” агнуурын бүс нутгуудад сумуудын ЗДТГазар болон ангийн нөхөрлөлүүдтэй хамтран нийт 30.0 гаруй сая төгрөгний санхүүжилтээр Монгол улсын улаан номд орсон туурайтан ан амьтанд зориулан өвс, давс хужир тавьж, биотехникийн арга хэмжээ авч ажиллаа.







Ногооннуур сумын Засаг даргын тамгын газартай хамтран тус сумын ан амьтан хамгаалах 7 нөхөрлөлийн ахлагч нарт Байгаль орчныг хамгаалах тухай, амьтны тухай хууль тогтоомж, нөхөрлөл, биотехникийн арга хэмжээний талаар сургалт зохион байгууллаа.



Алтанцөгц сумын БОХУБайцаагч болон байгаль хамгаалагчид ангийн нөхөрлөлүүдтэй хамтран тус сумын "Олоннуур" гэдэг газраас 25 шуудай байгалийн хужир бэлдэж тус сумын "Мундуйн" агнуурын бүс нутгийн Янгир ямаанд цацаж ажиллав.





Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын ажилтнууд, Экологийн цагдаагийн алба хаагчид, Ачит нуурын байгалийн цогцолборт газар болон Ногооннуур сумын байгаль хамгаалагчидтай хамтран Ачит нуурын усан холойд боогдсон Алтайн сугац загасны нийтдээ 4.5 тонн жараахайг хоёр тээврийн хэрэгслээр 7 км зайд байрлах Ховд голын усанд шилжүүлэн тавих ажлыг зохион байгуулан ажиллаа.



Ан амьтны эрүүгийн хэрэг, зөрчлийн шинжтэй 9 хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргаж, аймгийн Цагдаагийн газарт хүргүүлэв.

#### **ОЙН ТАЛААР:**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/181 дугаартай захирамжаар баталсан “Аймгийн хэмжээнд таван зуун мянган ширхэг мод тарьж ургуулах аян”-ыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 06-р сарын хугацаатай зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хаврын модны үзэсгэлэн худалдааг аймгийн төв талбайд зохион байгууллаа.

Үзэсгэлэнд аймгийн Сум дундын ойн анги болон “Ногоон Өлгийн Ой” ХХК, “Балгын” ХХК зэрэг аж ахуй нэгжүүд оролцон Улиас, Бургас, Хайлаас, Шар хуайс, Алим, Чавга, Үхрийн нүд, Чацаргана, Монос зэрэг 10 төрлийн тарьц суулгацыг худалдаалж иргэдэд тарих, арчлах зөвлөмж өглөө.







Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын улирлын мод тарих арга хэмжээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд 10 төрлийн нийт 31208 мод тарьсан. /урьдчилсан байдлаар/

№	Сумын нэр	Таригдсан		Бүгд дүн	Байгуулсан цэцгийн мандал м <sup>2</sup>	Мод тарих арга хэмжээнд оролцсон		Зарцуулсан зардлын тооцоо /мян.т/
		Модны тоо	Бут цөөгний тоо			ААНБ-ын тоо	Иргэдийн тоо	
1	Алтай	1200		<b>1200</b>	15	8	156	4000.0
2	Алтанцөгц	3500	1000	<b>4500</b>	30	6	185	8000.0
3	Баяннуур	2500	500	<b>3000</b>	6	8	240	3500.0
4	Булган	1220	280	<b>1500</b>	2	7	156	2000.0
5	Бугат	830	190	<b>1020</b>		6	5	2000.0
6	Буянт	300	750	<b>1050</b>		4	80	3500.0
7	Дэлүүн	2500	1000	<b>3500</b>	100	14	585	5400.0
8	Толбо	200		<b>200</b>	45	2	30	650.0
9	Цэнгэл	2000	11	<b>2011</b>		3	65	5000.0
10	Ногооннуур	660		<b>660</b>	4	4	80	1500.0
11	Улаанхус	1050		<b>1050</b>		10	59	2350.0
12	Сагсай	2330		<b>2330</b>	2	7	180	5500.0
13	Өлгий	7087	2100	<b>9187</b>	800	112	3,491	40000.0
<b>Нийт</b>		<b>25377</b>	<b>5831</b>	<b>31208</b>	<b>1004.0</b>	<b>191</b>	<b>5312</b>	<b>83400.0</b>

### УСНЫ ТАЛААР:

Усны тухай хуулийн 28.4 –т заасны дагуу 2023 оны хагас жилийн байдлаар иргэн, аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн хүсэлт, холбодох бусад бичиг баримтуудыг үндэслэн Дэлүүн,

Улаанхус сумуудын төвийн аж ахуйн нэгж байгууллагуудыг дулаанаар хангадаг Жанат ХХК, Цэнгэл, Толбо сумуудын төсөвт байгууллагуудыг дулаанаар хангаж буй “Агайын” ХХК, Алтай сумын төвийн аж ахуйн нэгжүүдийг дулаанаар хангадаг “Нуртөре” ХХК, Буянт сумын төвийн аж ахуйн нэгжүүдийг дулаанаар хангадаг “Ахпейл” ХХК, Толбо сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Эж улаан хатуу” ХХК, Сагсай сумын “Каде” ХХК – иудын халаалтын зууханд, Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулдаг “Жадыра”, “Гүлим”, “Жайнаш” халуун усны газууд болон Өлгий сумын төв үйл ажиллагаа явуулдаг Казос ХХКомпаниудын 2023 онд ус ашиглуулах дүгнэлтийг тус тус гаргаж хүргүүлэв.

Хар нуур Ховдголын сав газрын захиргаанаас гаргасан дүгнэлтийг үндэслэн “Эйч кей би интернэшнэл” ХХК, “Эрчим Баян-Өлгий” ХКомпаниудын 2023 оны ус ашиглуулах гэрээ байгуулж, төлбөр ногдуулан ажиллав.

Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоох талаар Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, Дэлхийн байгаль хамгаалах сангийн MWWF/ Монгол дах хөтөлбөрийн газартай хамтарч Цэнгэл, Улаанхус, Сагсай, Алтай, Буянт, Бугат Баяннуур, Алтанцөгц, Толбо, Дэлүүн, Ногооннуур сумдад очиж Сумдын удирдлагууд болон тухайн сумаас сонгогдсон ИТХурлын төлөөлөгч, сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал ард иргэдийг хамруулсан уулзалт зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж ажиллав.

Уг арга хэмжээний хүрээнд тухайн сумдуудад усны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, усны нөөцийг бохирдож хомстохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас урьдчилан сэргийлэх “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангуулах зэрэг асуудлаар холбогдох ажлын хэсгийн гишүүд мэдээлэл хийж, ард иргэдэд монгол, казак хэлээр брошур тарааж өгч ажилласан. Хамгаалалтын бүсийг 2023 оны 3 дугаар улиралд багтааж батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.



Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Ховд голын эрэгт цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “Усны үнэ цэн” сэдвээр Улаанхус ерөнхий боловсролын 7- 12 дугаар ангиудын сурагчдад сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, орон нутгийн радиогоор ард иргэдэд усны талаар мэдээлэл өгч, байгууллагын веб сайтад усны ашиглалт, хамгаалалтын талаар мэдээлэл түгээж ажиллав.





Сайдын 2023 оны 03 дугаар сарын 09 ний өдрийн 05 дугаар албан даалгаврыг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, түүний орчмын газрын хорогдсон малын сэг зэм нийт 48,9 тонн, бусад 40,8 тонн хуурай хог хаягдлыг цэвэрлэж устгах ажлуудыг зохион байгуулав.



2023 оны хагас жилийн байдлаар гаргасан ус ашиглуулах дүгнэлийн судалгааг гаргаж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газарт хүргүүлэв.

#### **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР:**

“Шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд 2023 оны 6 сард Даянгийн боомтыг сэргээн ашиглалтад оруулахдаа холбогдуулан Баян-Өлгий аймгийн болон БНХАУ-ын ШУӨЗО-ны хооронд хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор хоёр талын аялал жуулчлалын салбарын удирдлага болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНэгж, байгууллагуудын төлөөллүүдтэй цахим уулзалт зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд Хилийн боомтын захиргааны Цагааннуур, Даян боомтын төлөөлөгч, аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Аялал жуулчлалын холбоо болон аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНэгж байгууллагуудын 26 хүн оролцлоо.

Уулзалтаар хоёр улсын бүс нутгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал болон цаашдаа хөгжүүлэх талаар товч танилцуулж, Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор БНХАУ болон ОХУ-тай нягт хамтран ажиллах шаардлагатай байгааг илэрхийлэв.



0165-р ангиас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласныг холбогдуулан аялал жуулчлалын салбарын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, тус аймгийн “Аялал жуулчлалын өнөөгийн байдал ба тулгамдаж буй асуудлууд”-ыг танилцуулан, шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хэлэлцүүлэв.



2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Байгаль түүх, нийгэм судлаач Б.Баатар, ШУА-ийн харьяа Философийн хүрээлэнгийн Баян-Өлгий аймаг дахь салбарын ЭША-тай хамтран аймгийн Хурманханы нэрэмжит ХДТеатрт Булган нутгийн үзэсгэлэнт байгалийн түүх, соёл, аялал жуулчлалын гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгууллаа.

Тус үзэсгэлэнд Байгаль түүх, нийгэм судлаач Б.Баатар Баян-Өлгий аймгийн Булган сумын түүх соёл, байгаль экологийн гайхамшигт 80 гаруй дүр зургийг дэглэсэн юм.



Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас WELCOME TO MONGOLIA самбарыг аймаг бүрт орох гарах төв зам дагуу болон угтах, үдэх хаалганы орчимд самбарт байрлуулах талаар өгсөн үүрэг даалгаврыг дагуу Аялал жуулчлалын хөгжлийн төвийн 510.000 төгрөгийн санхүүжилтээр сурталчилгааны самбарыг замын 2 талд байршуулав.





|2023 оны “Наурыз”-ын баярын нээлтийн жагсаалын арга хэмжээнд 20 бүргэдчин, “Көк бар” 2 хос, “Кыз куар” 2 хос, Цагаан тэмээг хамруулав.



Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Ховд аймагт зохион байгуулсан “Мөнгөлөг шагшуурга” мөсний баярт Баян-Өлгий аймгийг төлөөлөн БОАЖГазрын дарга, аялал асуудал хариуцсан мэргэжилтэн 4 бүргэдчидтэй хамт оролцов.





Монголын зочид буудлуудын холбоотой хамтран аймгийн зочлох үйлчилгээний 14 нь Зочид буудлуудад “Welcome to Mongolia” шторк, менежер болон зочин угтагч ажилтнуудад энгэрийн тэмдэг гардуулах ажлыг зохион байгуулав.



2023-2025 оныг Монгол зочлох жил болгон зарласантай холбогдуулан Аймгийн нисэх буудлын газартай хамтран “Аеро”ХХК, Хүннү”ХХК компани болон аялал жуулчлалын салбарын компаниудын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулав.







Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгосонтой холбогдуулан “Аялал жуулчлалдаа бэлдье” аяныг 2023 оны 05-р сарын 02-ноос эхлэн аймгийн хэмжээнд нэг сарын хугацаатай зохион байгуулав.

#### **ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР:**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай 02 дугаар албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд нийтийн цэвэрлэгээний арга хэмжээ зохион байгуулав. Уг арга хэмжээнд 13 сумын 186 байгууллагын 3602 албан хаагчид оролцож нийт 266.6 гаруй тонн хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт буулгах ажлыг зохион байгуулав. Уг арга хэмжээнд:

Өлгий суманд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Ховд голын эргийг цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулах ажилд аймгийн ИТХ-ын ажлын алба, аймаг болон Өлгий сумын ЗДТГазар, МАНУТХГХЗахиргаа, Дэлхийн байгаль хамгаалах сан/WWF/-гийн Монгол дах хөтөлбөрийн газар болон МЭХ-ны Баян-Өлгий аймаг дахь салбартай хамтарч 15 тонн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллав.



Өлгий сумаас орох гарах 6 чиглэлийн хогийг 96 байгуулага, 25 ААНэгжийн 1500 гаруй иргэн оролцож 20 тонн гаруй хог хаягдлыг цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллаа.





Өлгий сум хариуцсан байгаль хамгаалагчид “Цамбагарав констракшн” ХХК-ийн Өлгий хотын “А” бүсэд орших эзэмшлийн газарт хуримтлагдсан их хэмжээний хог хаягдлыг ачиж, зайлуулах талаар үүрэг даалгавар өгсний дагуу тус компанийн эзэмшил газарт ил задгай хаясан 3 машин хог хаягдлыг ачиж зайлуулах ажлыг хийж гүйцэтгүүлэв.



Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэдэх Эко клубын сурагчид болон аймгийн хүүхдийн зөвлөлийн Уур амьсгалын дэд хорооны 50-иад багш, сурагчид хамтарч өөрсдийн санаачлагаар Өлгий-Толбо чиглэлд явах Шар нуурын постноос Эмпати сургууль хүртэлх хар зам дагуух ил задгай хаягдсан хог хаягдлыг цэвэрлэж, 1 тн хог хаягдлыг цуглуулж, нэгдсэн хогийн цэгт ачиж зайлуулан ажиллав.





Бугат суманд 6 байгууллага, 3 ААНэгжийн 242 гаруй албан хаагчид оролцож 22.6 гаруй тонн хог хаягдлыг цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллав.



Алтанцөгц суманд нийт 9 байгууллагын 256 Төрийн албан хаагчид цэвэрлэгээний арга хэмжээнд оролцож 5 гаруй тонн хог хаягдлыг хогийн цэгт буулгав.



Буянт сумын Засаг даргын А/31 тоот Захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор цэвэрлэгээг зохион байгуулж 5 байгууллага, 12 аж ахуйн нэгжийн 220 гаруй албан хаагч, дүйцүүлэх албаны 6 цэрэг 13 тонн орчим хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэж устгалаа.



Цэнгэл суманд Төрийн болон төрийн бус байгууллагуудын нийт 250 албан хаагчид оролцож 10 гаруй тонн хог хаягдлыг цэвэрлэв.





Тус суманд үйл ажиллагаа явуулдаг "SG GROUP" ХХКомпани орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд олгосон 30,000,000 (гучин сая) төгрөгөөр сумын хогийн цэгийн хогийг овоолж бохирдсон /40+10/ 50 гектар талбайг цэвэрлэх, манаачийн байр барих, манаачтай болгох ажлыг эхлүүлээ.



Алтай сумын төвийн болон Хар бут голын эрэг болон голдирол доторх ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 6 албан байгууллага, 15 гаруй аж ахуйн нэгжийн 519 хүн нийтийн цэвэрлэгээнд оролцож 31.5 тонн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллав.



Сагсай суманд 4-р сард 7 Төрийн байгууллага, 1 ТББ, 2 банк, 5 аж ахуйн нэгжийн нийт 250 хүн хамрагдаж 12 гаруй тонн хогийг цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт хүргүүлэн ажиллав. 5-сард аймаг сум хоорондын эзэнгүй хог хаягдлыг бүрэн арилгах, цэвэрлэх, ачиж



зайлуулах, замын хажуугийн цэвэрлэгээ хийлгэх, малын цэг зэм устгах халдваргүйтгэх зэрэг ажлыг аймгийн ХХҮХ-ийн нийтийг хамарсан ажлын сангийн хөрөнгөөр сумын ажилгүй 20 иргэдийг оролцуулсан цэвэрлэгээний ажлыг 7 хоног нийт 20 портер буюу 16 тн хог хаягдалыг устгаж ажиллаа.



Булган суманд Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/31 дүгээр удирдамжийн дагуу сумын төвийн болон Нарийн гол, Булган голын эрэгт их цэвэрлэгээний ажлыг 2 удаа зохион байгуулав. Уг арга хэмжээнд сумын ЗДТГ, Эмнэлэг, Цэцэрлэгийн 187 албан хаагч, ЕБСургуулийн 18 багш, ахлах ангийн 212 сурагч оролцож, 21 гаруй тонн хог хаягдлыг цэвэрлэв.



Баяннуур суманд 6 байгууллага 12 аж ахуйн нэгж, 5 хуалдаа үйлчилгээний 80 хүн хамрагдаж 4 гаруй тонн хог цэвэрлэв. БОАЖСайдын “Усны сав бүхий газрыг бохирдлоос хамгаалах” тухай” 05 дугаар албан даалгаврын хүрээнд ховд голын эрэг дагуух их хэмжээний хог хаягдлыг цэвэрлэх ажлыг тус тус зохион байгуулав.





Толбо сумын төвийн болон Баян-Өлгий-Ховд чиглэлийн хар замын хоёр тал, Улаан толгойн зогсоолын хог саванд хуримтлагдсан их хэмжээний хог хаягдлыг 5 байгууллагын 147 албан хаагчид оролцож 4 тонн хог цэвэрлэв.



Дэлүүн суманд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн болон ААНэгж байгууллагын 178 гаруй албан хаагч, ажилгүй 6 иргэнийг 10 хоног нийтийн цэвэрлэгээний арга хэмжээнд оролцуулж сумын эргэн тойрон, нийтийн эзэмшлийн зам, талбай гол булаг шандын орчмын 54,5 гаруй хог хаягдлыг цэвэрлэв.



Ногооннуур сумын эргэн тойроны хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг хагас жилийн байдлаар 2 удаа зохион байгуулж, 138 албан хаагч нийт 14 гаруй тонн хог хаягдлыг цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт буулгав.







Цагааннуур тосгонд Захирагчийн гаргасан А/21-р захирамжийн дагуу ажилтан албан хаагчид их цэвэрлэгээ хийж ажиллаа.



Улаанхус суманд 6 байгууллагын 150 гаруй ажилтан, албан хаагч 6 гаруй тонн хог цэвэрлэв.



Улаанхус сумын Хөх хөтөл багийн зам дагуух хур хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулав.





Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 02 дугаар “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай албан даалгаврын хүрээнд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын тушаалын дагуу аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуйн нэгж, байгууллагуудын ойр орчмын 50м газарт их цэвэрлэгээг тогтмол хийх, ангилан ялгах хогийн савтай болгох, хог шатаахгүй байх, нүхэн жорлонг ашиглалтаас хасах талаар шаардлага тавьж ажиллав.



### “ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ АЮУЛЫГ АВДАРЛАЯ-2” аян

“Бөмбөрцгийн Сүмбэ” хүүхдийн байгууллагаас санаачлан Боловсролын ерөнхий газар, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Жи Мобайл ХХК хамтран улс даяр зохион байгуулж байгаа “Гэрэлт ирээдүйн төлөө аюулыг авдарлая-2” уралдааныг ЕБС-иудын дунд зохион байгуулан ажиллав. Аяны хүрээнд аймгийн төвийн болон сумуудын ЕБС-иудын эко клубын багш, сурагчид, нийгмийн ажилтан, хөдөлмөрийн багш нарт гэмтэлтэй зайтай харьцах аюулгүй ажиллагааны заавар, аюултай хог хаягдал цуглуулахдаа эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр анги удирдсан багшийн зааварчилгаа дор савлах талаар заавар, зөвлөмж өгч ажилласан ба аяны хугацаанд нийт 3545 кг аюултай хаягдал / зай батерей, ашиглалтгүй бүх төрлийн гар утас, чихэвч, цэнэглэгч, антибиотик, эм бэлдмэл зэрэг/ цуглуулсан болно.





**Аюултай хог хаягдлын талаар:** Аймгийн хэмжээний Ерөнхий боловсролын сургуулиуд болон лабораторитой аж ахуйн нэгж, эмнэлгүүдэд хугацаа дууссан, урвалд орсон, хошго шошгогүй, удаан жил сургуулийн кабинет дотор зориулалтын бус газар болон ажлын байранд хадгалж байгаа 288.49 кг химийн бодисуудыг аймгийн Тагнуулын газар, Онцгой байдлын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Улаанбаатар хотод аюултай хог хаягдал устгадаг тусгай зөвшөөрөлтэй “Элемент” ХХК-тай хамтран сумуудаас ачих арга хэмжээг зохион байгуулж байна. Уг химийн бодисуудыг Улаанбаатар хот руу тусгай тээвэрээр тээвэрлэхэд шаардагдах 8.0сая зардлыг Аймгийн Онцгой Комиссын XII дугаар хуралдаанаар шийдвэрлүүлэв.



“ХОЛИО СОЛИО” ашиглахгүй байгаа зүйлсээ цуглуулж, хэрэгтэй хүнд дамжуулан дахин ашиглан эх дэлхийдээ амсхийх цаг өгье” арга хэмжээг МАНУТХГХЗахиргаа, ХТАлба, ЦШСГазар, МСҮТөвтэй хамтран зохион байгуулж, цуглуулсан 500 гаруй архины шилийг “АПУ”ХХК-ны Баян-Өлгий аймаг дахь салбарт, 600 гаруй салат, варенийн шилийг “Аниса”, “Толхын” таргийн жижиг дунд үйлдвэрт, 800 гаруй хуучин хувцас тоглоомуудыг МСҮТөвийн оёдлын ангид хүлээлгэж өгсөн.

**60 EARTH HOUR**

**“Холио Солио”**

Ашиглахгүй байгаа зүйлсээ цуглуулж, хэрэгтэй хүнд дамжуулан дахин ашиглан эх дэлхийдээ амсхийх цаг өгье

2023.03.25-ны өдөр 11:00 - 18:00 цаг хүртэл төв талбайд дахиврыг авчран эх дэлхийн цагт нэгдээрэй

Хувцас  
Тоглоом  
Варенье салат шил  
Архины шил / Апу ххк /  
Лааз хөнгөн цагаан  
Хуванцар

Жич: Апу ХХК-ийн архи, варенье, салатны шил, хөнгөн цагаан лаазыг эдийн засгийн зорилго оруулах боломжтой ба энэ удаагийн борлуулалтыг хэрэгтэй хүмүүст зарцуулах болно. Хувцас, тоглоомыг МСҮТ-ийн оёдлын ангид сурагчдаар дахин сэргээж хэрэгтэй хүнд өгнө.





**МАЛЫН СЭГ ЗЭМИЙГ УСТГАХ АЖЛЫН ТАЛААР:**

БОАЖСайдын 2023 оны 02, 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор аймгийн БОАЖГ-ын даргын А/03 дугаар тушаал гарч сумдын ЗДТГазар, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нарт сумуудын эзэнгүй хог хаягдал болон эзэнгүй газарт үхэж, хорогдсон мал амьтны сэг зэмийг цэвэрлэж халдваргүйжүүлэх даалгавар өгөгдсөн. Уг албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд 4 дүгээр сард аймгийн хэмжээнд 67.1 тонн, 5-р сард 68.4 тонн нийт 149.0 тонн эзэнгүй мал амьтны сэг зэмийг цэвэрлэж, нэгдсэн хогийн цэг дээр буулгаж халдваргүйжүүлэх ажлыг зохион байгууллаа. Үүнд:

Алтай суманд мал эмнэлэгийн малын эмч болон байгаль хамгаалагч нарын хамт үхсэн малын 3тонн гаруй сэг зэмийг цэвэрлэв.



Өлгий: Монголд Зочлох жил болгон зарласантай холбогдуулан “Эрүүл аюулгүй-цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд Өлгий сумын бүх багуудад хорогдсон мал амьтны 18 гаруй тонн сэг, зэмийг ачиж, зайлуулах ажлыг Өлгий сумын ЗДТГазар, ХТАлбатай хамтран зохион байгууллаа.



Сагсай сум: Сумын Засаг даргын 2023 оны А/22 дугаар захирамж хүрээнд орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчлөл тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм устгалын ажлыг 3 дугаар сарын сарын 16-17-ний өдрүүдэд сумын мал эмнэлгийн тасагтай хамтран зохион байгуулж, нийт 253 сэг зэмийг халдваргүйжүүлэлт хийж булж устгалаа.





Дэлүүн сум:Сумын төвийн эргэн тойрны болон шуудууны доторх үхэж хорогдсон мал амьтаны сэг зэмийг цуглуулан устгах, булах ажлыг сумын мал эмнэлгийн тасагтай хамтран зохион байгуулан ажиллавНийт 29.5 гаруй тонн сэг зэм устгав.



Бугат суманд Багийн Засаг дарга нар болон Мал эмнэлэгийн тасагтай хамтран мал амьтны 1.8 тонн гаруй сэг зэм хогыг түүж ачин, хогын цэгт хүргүүлэнэ халдваргүйжүүлэлт хийж ажиллав. Нийт 17 хүн оролцлоо.





Цэнгэл сум: сумын хогийн нэгдсэн цэг дээр 5м\*3м харьцаатай нүх ухаж мал амьтадын сэг зэмийг булах ажил хийв. Нийт 50 гаруй бод /үхэр, адуу/ малын сэг зэмийг ковш трактороор түрж овоолон зөөж нүхэнд булах ажиллагаа хийгдлээ.



Буянт сум: БОАЖСайдын 2023 оны 02-р сарын 28-ны өдрийн 02-р албан даалгаврын хүрээнд тус сум 2 удаа малын сэг зэм устгах, 1 удаа нийтийн цэвэрлэгээг зохион байгуулан 10 тн хог хаягдал болон малын сэг зэм устгав.



Буянт сумын Хөх эрэг багт...



Баяннуур: МЭТ-тэй хамтран сумын төвийн болон 3-р багийн хэмжээнд 3 удаа зохион байгуулж зүй бусаар хорогдсон 1.5 тонн малын сэг зэмийг хогийн цэгт буулгаж, устгав.





Алтанцөгц суманд нэгдсэн хогийн цэг дээр сэг зэм устгах нүх бэлтгэж, 9 тонн гаруй мал амьтны сэг зэгийг устгаж, халдваргүйжүүлэлт хийв.





Улаанхус сум: Нийтийн эдэлвэр газар, зам, Ховд, Согоог голуудын эрэг дагуу үхсэн малын болон амьтны сэг зэм, хогийг ачиж, зайлуулаж, устгалд оруулах ажлыг тус сумын төвлөрсөн 11.2. 4. 8. 7-дугаар багуудад зохион байгуулав.



Булган сум: Сумын төвд зүй бусаар хорогдсон мал амьтны сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулж, 1тонн гаруй сэг зэмийг нэгдсэн хогийн цэгт буулган халдваргүйжүүлэлт хийлгэв.



Толбо сумын нутаг дэвсгэрт өвөл болон хаврын цагт үхэж хорогдсон мал амьтны сэг зэмийг устгаж, халдваргүйжүүлэх ажлыг тус сумын байгаль хамгаалагч Мал эмнэлгийн тасгийн албан хаагч нартай хамтран хийж гүйцэтгэв.





Ногооннуур сум: Сумын төвийн эргэн тойроны үхсэн мал амьтны сэг зэмийг, тус сумын мал эмнэлгийн тасгийн албан хаагч болон малын эмч нартай хамт 48 гаруй бог, бод малын сэг зэмийг сумын төвийн нэгдсэн хогийн цэгт хүргэж устгах арга хэмжээ авч ажиллаа.



Ногооннуур сумын Бөхмөрөн голын эрэгт..



Цагаан нуур тосгоны ойр орчмын малын сэг зэмийг ачиж хогийн цэгт буулгаж ариутгалын бодисоор халдваргүйжүүлэлт хийж ажиллаа.



Улаанхус сумын Согоог баг. Багийн үхсэн мал амьтадын сэг зэмийг ачиж зайлуулж, устгалд оруулан ажиллав.





Улаанхус сумын Хөх хөтөл баг. Мал амьтадын сэг зэмийг ачиж хогийн цэгт хүргэж ажиллав.



Алтанцөгц, Ногооннуур сумын БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагчид хариуцсан нутаг дэвсгэрийн ард иргэд, ААНэгж, байгууллагуудад байгаль орчны багц хууль хууль тогтоомжууд болон БОАЖСайдын 2023 оны 02, 05 дугаар албан даалгавруудыг танилцуулан, амьдарч буй газар нутгийн голын эрэгт нүхэн жорлон байршуулахгүй байх, ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ахуйн хог хаягдал, үхсэн мал амьтны сэг зэмийг ил задгай хаяхгүй байх талаар сурталчилгааны ажлыг зохион байгуулав.





**САНХҮҮ, ТӨСВИЙН ТАЛААР**

1. Тус газар 2023 оны 2-р улиралын байдлаар Орон нутгийн төсвөөс 371101.0 мянган төгрөгний санхүүжилт, өөрийн орлогоос 1750.2 мянган төгрөгний санхүүжилтийг бүрдүүлж нийт 372851.2 мянган төгрөгний төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулав. Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/46 тоот захирамжаар 46 хүний орон тоогоор орон тоог баталуулж удирдах ажилтан 1, мэргэжилтэн 11, байгаль хамгаалагч 21, үйлчилгээний ажилтан 10, гэрээт ажилтан 3 байна. Өөрийн орлогод төсөвт ус ашиглах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлснөөс 650.0 мянган төгрөг, бусад орлогоос 1100.2 мянган төгрөг оруулж төлөвлөгөөг 100% биелүүлсэн.

2. Нийт төсвийн 298413.6 мянган төгрөгийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд /төсвийн 80%-ийг/, 37302.0 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-д /төсвийн 10%-ийг/, 8322.4 мянган төгрөгийг байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд /төсвийн 2.2%-ийг/, 3772.2 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардалд /төсвийн 1%-ийг/, 112.8 мянган төгрөгийг нормативт зардалд, 25.8 мянган төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 1353.6 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд, 351.4 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр хураамжын зардалд, 8750.0 мянган төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажилд /төсвийн 2.3%/, 252.0 төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 12600.0 мянган төгрөгийг 1 хүний тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд тус тус зарцуулав.

3. Холбогдох байгууллагуудад хамтран ажиллах гэрээ, өдөр тутмын санхүүгийн төлбөр тооцооны гүйлгээ хийж санхүүгийн улирал, хагас жилийн тайлан мэдээ, татварын улирал, хагас жилийн тайлан, нийгмийн даатгалын сар бүрийн тайлан, байгууллагын шилэн дансны тухай бүрийн, өдөр тутмын мэдээлэлүүдийг хугацаанд үнэн зөв байршуулж тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд гаргаж өгч удирдлагыг мэдээ мэдээллээр бүрэн хангаж ажиллав.

**ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЛААР:**

2023 оны хагас жилийн байдлаар иргэдээс БОАЖГазарт хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт %
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа Хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	82	81	-	-	1	100%



**2023 оны хагас жилийн иргэдээс төрийн захиргааны төв байгууллагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт / хэлбэрээр /**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	82	81	-	-	-	-	-
	Дүн	-	-			-		

Тайлбар:Иргэдээс 82 өргөдөл ирснээс ажил эрхлэлттэй холбоотой 8, санхүүгийн дэмжлэг хүссэн 1, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ гаргуулах тухай 59, бусад 13 өргөдөл ирсэн ба гомдол 1 болно.

**Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга /%-аар/**

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	. Иргэдээс 82 өргөдөл ирснээс ажил эрхлэлттэй холбоотой 8, санхүүгийн дэмжлэг хүссэн 1, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ гаргуулах тухай 59, бусад 13 өргөдөл ирсэн ба гомдол 1 болно.

Тайлан нэгтгэн гаргасан мэргэжилтэн:

Н.Болатхан

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Ш.Марат